



ТӨРИЙН ЭРХ МЭДЭЛ ХУВААРИЛАХ ЗАРЧИМ

Нийгэм судлал 10-р анги

Багш Д.Уранцэцэг

Хичээлийн зорилго

- Монгол Улсын төрийн байгууллын талаар Монгол Улсын Үндсэн хуулиас мэдэх
- Төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдсан үзэл баримтлалтай холбон тайлбарлах
- Иргэд ямар нөхцөл, шаардлагын улмаас захиргааны байгууллагад иргэд ханддаг талаар мэдэх

Тулгуур ойлголт

Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.

Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.

Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.

Монгол Улсын Их Хурал

Эх сурвалж: Монгол Улсын Үндсэн хууль УБ.1992

Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.

- УИХ-ын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.
- УИХ-ын гишүүний бүрэн эрх нь Төрийн сүлдэндээ тангараг өргөнө.
- **УИХ-ын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар сонгоно.**

УИХ бүрэн эрхээ чуулган, Байнгын хороод зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ.

- УИХ-ын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулна.**
- УИХ үйл ажиллагааныхаа зохих салбар, чиглэлээр Байнгын хороодтой байна**
- УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болно.**

Монгол Улсын Ерөнхийлөгч

Эх сурвалж: Монгол Улсын Үндсэн хууль УБ.1992

Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.

- Ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш гуч хоногийн дотор “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ эрх чөлөө, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн хамгаалж, Үндсэн хуулийг дээдлэн сахиж, Ерөнхийлөгчийн үүргийг шударгаар биелүүлэхээ батлан тангараглая” хэмээн Улсын Их Хуралд тангараг өргөнө.
- Ерөнхийлөгч Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.
- Ерөнхийлөгчийг түр эзгүйд бүрэн эрхийг нь Улсын Их Хурлын дарга хэрэгжүүлнэ.
- Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байна. Б Э
- Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд хуульд нийцүүлэн зарлиг гаргана.
- Ерөнхийлөгч Улсын Их Хуралд ажлаа хариуцна. –эрх мэдэл
- **Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар огцруулна.39-дээш**

Монгол Улсын Засгийн газар

Эх сурвалж: Монгол Улсын Үндсэн хууль УБ.1992


Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.

- Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ.
- Засгийн газрын бүрэн эрх Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томилсноор эхэлж, шинэ Ерөнхий сайдыг томилсноор дуусгавар болно.
- Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.
- Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна. Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө.
- Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.
- Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана

Иргэд Засгийн газарт санал өгөх боломжууд

- Иргэд Засгийн газарт саналаа захидлаар илэрхийлэх
- Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төвд саналаа өгөх
- ТҮЦ машинаар саналаа өгөх
- Нэг цонхны үйлчилгээнд хандаж саналаа өгөх
- Засгийн газрын мэдээллын вэб сайтад хандаж саналаа өгөх
- Орон нутагт төр захиргааны байгууллагадаа хандаж саналаа өгөх

ТӨРИЙН ЭРХ МЭДЛИЙН ХУВААРИЛАЛТЫН ХАРИЛЦАН ТЭНЦЭЛ



Даалгавар-1

Сэтгэгчдийн үзэл баримтлалыг уншаад
хүснэгтийг нөхөж бичнэ үү?

Сэтгэгчид	Ижил тал	Ялгаатай тал	Давуу тал	Сул тал
Ш.Монтескье				
Ж.Локк				

Даалгавар-2

Дараах асуултанд хариулаарай

- 1.Засаглал ба албадлага хоорондын уялдаа холбоог тайлбарлан бичнэ үү?
- 2.Ямар нөхцөл, шаардлагын улмаас захиргааны байгууллагад иргэд ханддаг вэ?

Даалгавар-3

Төрийн байгууллагуудын эрх зүйн актуудыг зөв харгалзуулна уу?

№	Төрийн байгууллага	Эрх зүйн актын төрөл	Хариулт
1.	Монгол улсын Үндсэн хуулийн цэц	Хууль	
2.	Монгол Улсын Их Хурал	Тогтоол	
3.	Монгол улсын Ерөнхийлөгч	Зарлиг	
4.	Монгол улсын Ерөнхий сайд	Шийдвэр	
5.	Монгол улсын Засгийн газар	Захирамж	
6.	Аймаг ,Нийслэлийн засаг дарга	Тушаал	



Гэрийн даалгавар

1. Даалгавар 1,2,3-г дэвтэртээ хийгээрэй.
 2. Сурах бичгийн 109-113 хуудсыг сайн уншиж судлаарай.
- 